



2023 оны 12 сарын 31

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙ САНХҮҮГИЙН  
БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**



**АЯА ТАКС АУДИТ ХХК**



**АЯА ТАКС АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, СБД, I хороо, V  
хороолол, 14251, Чингисийн өргөн чөлөө  
19-Б Бизнес тауэр 11 давхар Утас:  
99994447, 98658500

2024.04.15 № 24/  
Танай -ны № 24/ -т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Бид Улаанбаатар хивс ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогууд, бусад тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Улаанбаатар хивс ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангуудад санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Санхүүгийн тайландаа удирдлагын хүлээх хариуцлага**

Компанийн удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлагыг болон залилан эсвэл алдаанаас шалтгаалан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг хангахад шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлагыг хүлээнэ.

**Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний хүлээх хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан

**Аяа Такс Аудит ХХК**

материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлүүдийн үнэлгээг багтаасан аудиторын шийдлээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалzan үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ.

Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бodoх бүртгэлийн тооцооллуудын бодитой байдал, санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгыг үнэлэх ажлуудыг багтаана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалттай дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.



**АЯА ТАКС АУДИТ ХХК  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛ УЛС**

**2024 ОНЫ 4 ДУГААР  
САРЫН 15.-НЫ ӨДӨР**